

ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БОЛОН ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫН БАТАЛГАА

ШҮҮГЧИЙН ТОМИЛГООНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эрх зүйт төрийн үндэс нь шүүхийн хараат бус байдлыг хангах замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явдал байдаг бөгөөд шүүхийн томилгооны механизм үүнд чухал нөлөөтэй гэж үздэг.¹ Учир нь шүүгчийн үнэнч, шударга, хараат бус байдал нь шүүгчийг томилох механизмтай шууд холбоотой. Хэрэв шүүгч өөрийг нь томилсон, эсхүл шүүгчийг сонгон шалгаруулах, томилох процесст оролцдог субъектүүдээс ямар нэгэн байдлаар хараат байх юм бол шүүгчийг шударга шийдвэр гаргана гэж найдах боломжгүй бөгөөд энэ байдал нь тухайн орны эрх зүйн тогтолцооны хүлээн зөвшөөрөгдөх чанарыг бүхэлд нь доош татдаг аюултай.²

Улс орнуудад хэрэгжүүлж буй шүүхийн томилгооны процедур адил биш боловч үүнийг томилох болон сонгох механизм гэж хоёр ангилж болно.³ Манай улсын хувьд шүүгчийг сонгон шалгаруулаад томилдог олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлдэг ба 2013 онд шүүхийн тухай багц хуулийг баталж шүүх эрх мэдлийн хүрээний эрх зүйн зохицуулалтыг шинэ түвшинд гаргаад байна. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар анхан шат, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгчид

тавигдах шаардлагыг нарийвчлан зааж, нэр дэвшигчийг шалгах арга, ажиллагаа болон сонгон шалгаруулах тогтолцоонд зарчмын шинжтэй хэд хэдэн өөрчлөлт оруулсны зэрэгцээ шүүгчийг огцруулах, чөлөөлөх үндэслэл, журмыг нарийвчлан зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлээд байна.

Гэсэн хэдий ч шүүгчийн сонгон шалгаруулах болон шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх арга, ажиллагаа нь дэвшилтэт байдлаар хэрэгжихгүй, шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагааг албан тушаалтан үзэмжийнхээ хүрээнд шийдвэрлэх бололцоо оршоор байна. Мөн шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн үед Үндсэн хуулийн дагуу шүүгч хугацаагүй томилогдох зарчим зөрчигдөж, зарим шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, зарим шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүй шилжүүлэн томилсон тохиолдол гарлаа. Түүнчлэн шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоонд голлох үүрэгтэй оролцдог Шүүхийн мэргэшлийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ) -ийн хараат бус, бие даасан байдал хангалттай хэмжээнд хангагдаагүй байна. Тухайлбал, Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгч ШЕЗ-ийн санал болгосныдагуу шүүгчийг томилдог

атал, Шүүхийн захиргааны тухай хуулиар ШЕЗ-ийн бүрэлдэхүүнийг мөн адил томилдог болсныг шүүгч, судлаачид шүүмжилж байна.

ННФ-ын дэмжлэгтэйгээр хийгдсэн судалгаанд үндэслэн шүүгчийн томилгооны механизмыг цаашид боловсронгуй, хараат бус болгоход чиглэсэн хэд хэдэн багц зөвлөмжийг энэхүү Бодлогын асуудлаар танилцуулахыг зорилоо. Судалгааны дэлгэрэнгүй тайланг www.forum.mn хаягаар үзнэ үү.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Шүүгчийн томилгоо, сонгон шалгаруулалтад оролцдог субъектүүдийн хараат бус байдлыг бэхжүүлэх арга зам

Шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн томилгоонд голлох үүрэгтэй оролцдог Шүүхийн мэргэшлийн хороо, ШЕЗ зэрэг байгууллагуудын хараат бус, бие даасан байдал хангагдсан, хариуцлагатай байж гэмээ нь шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн томилгоо шударга, хараат бус явагдах нөхцөл бүрэлдэнэ.

1. *Шүүхийн мэргэшлийн хорооны дарга, гишүүнийг томилох, чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг*



“Оюуны-Инноваци” Эрх зүйн судалгааны төв 2011 онд клубын хэлбэрээр ажиллаж байгаад 2013 онд төрийн бус байгууллага болж өөрчлөн байгуулагдсан. “Оюуны-Инноваци” ТББ нь Монгол Улсад эрх зүйн шүүмж судлалыг хөгжүүлэх болон мониторинг, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ хийх, хууль, эрх зүйн талаар бодлогын болон хавсарсан судалгаа хийдэг.


“Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа” сэдэвт бодлогын шинжилгээнд суурилсан энэхүү Бодлогын асуудлыг тус байгууллагын судлаач П.Баттулга, судлаач М.Мөнхжаргал, зөвлөх судлаач хууль зүйн ухааны магистр, докторант Ж.Хунан нар хийж гүйцэтгэлээ.

боловсронгуй болгох. Шүүхийн мэргэшлийн хороо аль нэг шатны шүүх, түүний удирдлагаас хараат бус, бие даасан, хөндлөнгийн бүтэц байвал шүүгчийн албан тушаалд ажиллах хүмүүсийг зөв, шударга, ил тод, хариуцлагатай арга хэлбэрээр тодруулахаас шүүхийн чанар шууд хамаардаг. Шүүхийн захиргааны тухай хуулийн 23.5-д “Мэргэшлийн хорооны даргыг гишүүдийнх нь саналыг үндэслэн Ерөнхий зөвлөл томилно” гэж заасан байна. Гэтэл мэргэшлийн хорооны дүрмийн⁴ 2.8-д “Мэргэшлийн хорооны даргад санал болгосон гишүүнийг Ерөнхий зөвлөл томилохоос татгалзвал Мэргэшлийн хороо ажлын 3 өдрийн дотор өөр гишүүнийг санал болгоно.” гэж зохицуулжээ. Энэ нь Шүүхийн захиргааны хууль дахь “үндэслэн” гэсэн «императив» (тулган шаардсан) заалтыг Мэргэшлийн хорооны дүрмээр «альтернатив» (үзэмжээрээ сонгон хэрэглэх) заалт болгосон хэрэг. Иймд Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож уг хороог ШЕЗ-өөс хамааралгүй, бие даасан байгууллага болгох шаардлагатай байна.

2. *ШЕЗ-ийн дарга, гишүүдийг Ерөнхийлөгч томилдог хуулийн зохицуулалтыг хүчингүй болгох.* Шүүгчид төдийгүй судлаачид ШЕЗ-ийн бүрэлдэхүүний томилгоог Ерөнхийлөгчид хамааруулах тохиолдолд Ерөнхийлөгч шүүх эрх мэдэлд бүрэн эрхтэй болох бөгөөд шүүх болон шүүгчид Ерөнхийлөгчийн нөлөөлөл ихсэж, ШЕЗ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах баталгаагаа алдана гэж үздэг.⁵ Иймд ШЕЗ-ийн дарга, гишүүдийг Ерөнхийлөгч томилдог хуулийн зохицуулалтыг хүчингүй болгож, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгогдсоноор эрх бүхий байгууллага, албан тушаалтан томилсноор шууд эхэлдэг байх, ШЕЗ-ийн даргыг аль нэг субъектээс томилох биш, зөвлөлийн гишүүд дотроосоо, эсхүл нийт шүүгчдийн зөвлөгөөнөөс шууд сонгодог байх нь зүйтэй.

3. *ШЕЗ-ийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх.* 2013 онд батлагдсан Шүүхийн захиргааны тухай хуулиар ШЕЗ-ийн бүрэлдэхүүний тоог хэт цөөрүүлж 5 хүний бүрэлдэхүүнтэй байхаар хуульчилжээ. Одоогийн зохицуулалтаар шүүгчийг сонгон шалгаруулах, томилох ажиллагаа мөн шүүгчийг сэлгэн ажиллуулах, шилжүүлэн томилох, огцруулах, чөлөөлөх зэрэг шүүхийн тогтолцооны нарийн төвөгтэй асуудлыг 2 хүний саналаар шийдвэрлэх боломжтой болгосон. Бусад улсын Шүүхийн зөвлөл болон Шүүхийн зөвлөлтэй ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудын бүрэлдэхүүний тоог харьцуулан дараах графикт үзүүлэв.⁶

ШЕЗ-ийн бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх нь уг зөвлөл аль нэг байгууллага, албан тушаалтнаас



төдийгүй зөвлөлийн гишүүд бие биеэсээ хараат бус байх, шүүгчид нэр дэвшигчийг шударга, бодитой үнэлэхэд ач холбогдолтой. ШЕЗ-ийн бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх нэг арга нь орон тооны бус гишүүдийг бий болгох явдал юм. Ингэх нь төсвийн хувьд хэмнэлттэй төдийгүй, ШЕЗ-ийн дотоод хяналтыг сайжруулахад чухал нөлөөтэй. Орон тооны бус гишүүдийг анхан, давж заалдах, хяналтын шатны шүүх, Олон Улсын Шүүгчдийн холбооны гишүүн болох Монголын Шүүгчдийн холбоо ТББ, Хүний эрхийн үндэсний комиссын төлөөллөөс⁷ бүрдүүлэхээр хуульчлах, ингэхдээ орон тооны бус гишүүдийн тоо нь орон тооны гишүүдийн тооноос илүү байхаар зохицуулалт хийх нь зүйтэй гэж үзэж байна.

4. *ШЕЗ-ийн гишүүний сонгуулийн журмыг тодорхой болгох.* Шүүхийн захиргааны тухай хуульд анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн төлөөллийг тухайн шатны шүүхийн нийт шүүгчдийн зөвлөгөөнөөр сонгож, Ерөнхийлөгчид санал болгоно гэж заасан боловч ШЕЗ-ийн гишүүнд хэрхэн нэрээ дэвшүүлэх, хуралдааныг хэн даргалах, ямар журмаар санал хураалт явуулах (нууцаар, илээр) зэрэг сонгуулийн процессыг зохицуулсан заалтыг огт оруулаагүйн улмаас уг сонгууль илээр явагдаж шүүгчдийн саналаа чөлөөтэй илэрхийлэх боломж хаагдсан байна. ШЕЗ-ийн гишүүнийг сонгох сонгуулийг ил санал хураалтаар явуулах тохиолдолд Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч өөрт нь хэн санал өгсөн, өгөөгүйг мэдэх боломжтой бөгөөд энэ нь эргээд тухайн шүүгчдийн эрх зүйн байдалд эерэг, сөргөөр нөлөөлөх талтай. Иймд ШЕЗ-ийн гишүүнийг сонгох сонгуулийн процесс (нэр дэвшүүлэх ажиллагаа, хуралдааны журам гэх мэт), үндсэн зарчмууд (санал хураалт нууц байх, хараат бус тооллогын комиссыг оролцуулах гэх мэт)-ыг хуульчлах, тусгай журам гаргах шаардлагатай.

5. *ШЕЗ-ийн гишүүнд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох.* Шүүхийн захиргааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь хэсэгт ШЕЗ-ийн дарга, гишүүнийг чөлөөлөх, огцруулах үндэслэлүүдийг заасан боловч үүнийг ямар журмаар шийдвэрлэх, хэрхэн шалгаж

тогтоох зэрэг процессын асуудлыг зохицуулаагүй байна. Шүүхийн захиргааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.10 дахь заалтаар ШЕЗ-ийн даргад “ШЕЗ-ийн гишүүнийг энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэлээр чөлөөлөх, огцруулах тухай саналыг тухайн нөхцөл бий болсноос хойш ажлын 10 өдрийн дотор томилсон байгууллагад мэдэгдэх” бүрэн эрхийг олгосон нь ШЕЗ-ийн дотоод хараат бус байдал алдагдах нөхцөлийг бүрдүүлжээ.

Шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх арга, ажиллагааг боловсронгуй болгох арга зам

1. *ШЕЗ-өөс нэр дэвшигчийг сонгох процессыг боловсронгуй болгох.* Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар ШЕЗ нь шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгож томилуулдаг. Мэргэшлийн шалгалтын дүн болон бусад байгууллагаас өгсөн дүгнэлтээр хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг шүүгчээр томилдог байх нь шүүгчийн албан тушаалд өндөр мэдлэг, чадвартай хуульчдыг ажиллуулахаас гадна “шүүгчийн томилгоонд улс төрийн нөлөөлөл өндөр байдаг” гэсэн олон нийтийн бодлыг өөрчлөх ач холбогдолтой. ШЕЗ-өөс 2014-2015 онд нийт 180 хүнийг⁸ Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж Ерөнхий шүүгч, шүүгчийн албан тушаалд томилуулжээ. Эдгээр 180 томилогдсон шүүгчээс 79 нь тухайн шүүхийн шүүгчийн сул орон тоонд сонгогдох боломжтой оноог аваагүй байна. ШЕЗ эдгээр шаардлага хангаагүй нэр дэвшигчдийг ямар үндэслэлээр Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн нь тодорхой бус байна. Үүнийг Үндсэн хуульд нийцүүлэн шийдвэрлэх нэг арга нь Шүүхийн мэргэшлийн хорооноос орон тоо тус бүрт хамгийн өндөр үнэлгээ авсан 3 нэр дэвшигчийг Шүүхийн ШЕЗ-ийн ярилцлагад оруулах нь зөв. ШЕЗ эдгээр нэр дэвшигчтэй ярилцлага хийж хамгийн өндөр оноо авсан нэг нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгодог зохицуулалтыг бий болгох нь зүйтэй.
2. *Шүүгчийн сонгон шалгаруулалтад ил тод байдлыг хангах.* Шүүгчийн томилгоонд ил тод байдал, олон нийтийн хяналтыг бий болгох нь шүүхэд ажиллах хамгийн чадвартай хүнийг сонгох, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг олж авахад тэргүүн зэргийн ач холбогдолтой. ШЕЗ-ийн шүүгчийг томилох, албан тушаал дэвшүүлэх, огцруулах, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх хуралдааны санал хураалтыг илээр явуулснаар “шүүгчийн сонгон шалгаруулалт ил тод, шударга” болох зорилгод хүрэхэд дөхөм болох бөгөөд ШЕЗ-ийн гишүүн ямар боловсролтой, ямар туршлагатай хүнийг дэмжиж санал өгсөн, бодит шалгуурыг үндэслэж нэр дэвшигчид санал өгч байгаа эсэхийг хянах, цаашлаад тухайн шүүгч мэргэжлийн, ёс зүйн ноцтой алдаа гаргасан үед ШЕЗ-ийн гишүүдээс тайлбар шаардах боломжтой болно.⁹
3. *Хуульчдын холбооны дүгнэлтийн үр дагаврыг тодорхой болгох.* Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Монголын Хуульчдын холбоо нь

шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг гаргадаг. Хуульчдын холбооноос нэр дэвшигчид “хангалтгүй” гэсэн дүгнэлт өгсөн байхад ШЕЗ үүнийг үл харгалзан тухайн нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлвэл Хуульчдын холбооноос дүгнэлт гаргаж байгаагийн ач холбогдол гарахгүй. Иймд нэр дэвшигч Хуульчдын холбооноос хангалтгүй үнэлгээ авсан бол тухайн нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхгүй байх зохицуулалтыг хуульчлан баталгаажуулах шаардлагатай байна.

4. *Шүүгчээр томилуулахаар ШЕЗ-өөс өргөн мэдүүлсэн нэр дэвшигчийг Ерөнхийлөгч ямар хугацаанд шүүгчээр томилохыг хуульд тодорхой тусгах.* Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18.7-д “Ерөнхийлөгч шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх болон огцруулах тухай ШЕЗ-ийн саналыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор уг асуудлыг шийдвэрлэнэ.” гэж заасан хэрнээ Ерөнхийлөгч ШЕЗ-өөс өргөн мэдүүлсэн хүнийг ямар хугацаанд багтаан томилохыг зохицуулаагүй нь нэр дэвшигч шүүгчээр томилогдох эсэх нь хэдэн долоо хоногоос хэдэн сараар тодорхойгүй үргэлжилж нэр дэвшигчид “хүлээлт” үүсгэдэг. Иймд шүүгчээр томилуулахаар ШЕЗ-өөс өргөн мэдүүлсэн нэр дэвшигчийг Ерөнхийлөгч ямар хугацааны дотор шүүгчээр томилохыг хуульд тодорхой тусгах шаардлагатай.
5. *Шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгч томилохоос татгалзах үндэслэлийг тодорхой болгох.* Ерөнхийлөгч ШЕЗ-өөс санал болгосон хүнийг томилохоос татгалзсан 27¹⁰ тохиолдол гарсан байна. Ерөнхийлөгчийн татгалзсан тохиолдлуудыг судлан үзэхэд зөвхөн “... –ийг Ерөнхийлөгч шүүгчээр томилохоос татгалзлаа” гэсэн утга бүхий албан бичгийг Тамгын газар нь ШЕЗ рүү явуулдаг, зарим тохиолдолд албан бичгээр ч мэдэгдээгүй бөгөөд ийнхүү томилохоос татгалзсан үндэслэл, шалтгаанаа тодорхой тайлбарласан тохиолдол байгаагүй. Иймд ШЕЗ-өөс санал болгосон нэр дэвшигчийг Ерөнхийлөгч шууд томилохоос татгалзах бус тухайн нэр дэвшигч хуулиар тогтоосон шүүгчид тавигдах болзол, шаардлагыг хангахгүй талаар үндэслэл бүхий эргэлзээ байгаа бол асуудлыг дахин нягтлуулахаар ШЕЗ-д буцаах, харин уг үндэслэлийг ШЕЗ нягталж Ерөнхийлөгчийн томилохоос татгалзсан шалтгаан нотлогдвол өөр хүний нэрийг санал болгох, нотлогдоогүй тохиолдолд тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох эрхтэй байх нь зүйд нийцнэ. Мөн шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгч томилохоос татгалзвал нэр дэвшигч энэ шийдвэрийг эс зөвшөөрч Үндсэн хуулийн цэцэд хандах эрхийг хуульчлан баталгаажуулах шаардлагатай.

Шүүгчийг сэлгэн ажиллуулах болон шилжүүлэн томилох ажиллагааг боловсронгуй болгох арга зам

1. *Шүүгчийг сэлгэн ажиллуулах, шилжүүлэн томилох журмыг тодорхой болгох.* Шүүгчийн эрх зүйн

байдлын тухай хуульд шүүгчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах ойлголтын зөрүүг тодорхойлон хуульчилж, шилжүүлэх болон сэлгэн ажиллуулахад баримтлах шалгуур, шаардлага, хугацаа, журмыг нь хуульд нарийвчлан тусгах, мөн сэлгэн ажилласан буюу шилжин томилогдсон шүүгч болон түүний гэр бүлийг орон байраар хангаж, нийгмийн баталгааг бүрдүүлэх талаар хуульд тусгайлан оруулах, үүнд шаардлагатай төсөв хөрөнгийг шүүхийн багц төсөвт урьдчилан суулгаж өгч байх нь зүйтэй байна.¹¹ Шүүгчийг өөрийнх нь зөвшөөрлөөр сэлгэн ажиллуулах, шилжүүлэн томилох нь нэг талаас шүүгчийн албаны хараат бус байдлыг хангах нэг механизмд ордог. ШЕЗ-өөс шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр шилжүүлэх, сэлгэн ажиллуулах санал гаргасан, шүүгчдэд шахалт үзүүлсэн тохиолдолд ШЕЗ-ийн гишүүнд хариуцлага хүлээлгэх тухай зохицуулалтыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хуульд нарийвчлан тусгах шаардлагатай.

2. *Шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн үед хийгдэх шүүгчийн томилгооны процедурыг тодорхой болгох.* 2013, 2015 онд тус тус батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн дагуу хийгдсэн шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр шүүгчдийг өөрчлөн зохион байгуулагдсан шүүхэд шилжүүлэн томилох явцад Ерөнхийлөгч 13 шүүгчийг өөрчлөн байгуулагдсан шүүхэд нь огт томилохгүйгээр албан тушаалаас нь огцруулсан, шүүгчдээс зөвшөөрлийг нь авалгүйгээр өөрчлөн зохион байгуулагдсан шүүхэд нь бус огт өөр шүүхийн шүүгчээр шилжүүлэн томилсон, зарим шүүхүүд нэгдэж нэг шүүх болсон байхад тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн орон тоонд сонгон шалгаруулалт явуулалгүйгээр шууд Ерөнхий шүүгчийг томилсон зэрэг алдаа, дутагдлууд гарлаа.¹² Шүүхийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн үед хийгдэх шүүгчийн томилгооны процедурыг тодорхой болгох

үүднээс Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлд дараах агуулгатай заалтууд нэмэх шаардлагатай. Үүнд:

- 1) шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн тохиолдолд шүүгчийг зөвхөн өөрчлөн зохион байгуулагдсан шүүхэд нь шилжүүлэн томилно.
- 2) аль нэг шүүхийн шүүгчийн орон тоо цөөрсөн тохиолдолд тухайн шүүхийн шүүгчийн дунд сонгон шалгаруулалт явуулж энэ хуулийн 13.2-т заасны дагуу эрэмбэлж, өндөр оноо авсан шүүгчдийн албан тушаалыг хэвээр үлдээнэ. Бусад шүүгчийн хувьд өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн орон тоо дутуу байгаа өөр ижил шатны шүүхэд шилжүүлнэ.
- 3) татан буулгасан, өөрчлөн зохион байгуулсантай холбоотойгоор шүүгчийн орон тоо цөөрсөн, орон тоо хасагдсан тохиолдолд тухайн шүүхийн шүүгчийг өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн орон тоо дутуу байгаа өөр ижил шатны шүүхэд шилжүүлэн томилно.
- 4) дээр дурдсан нөхцөлүүд (1-3)-ийн дагуу шилжүүлэн томилогдох шүүгчдийн тоо шүүгчийн сул орон тооноос илүү гарсан тохиолдолд тэдний дунд сонгон шалгаруулалт явуулж энэ хуулийн 13.2-т заасны дагуу эрэмбэлж өндөр оноо авсан шүүгчийг тухайн шүүхийн шүүгчээр томилно.
- 5) шүүгчийн орон тоо цөөрсөн, шүүхийг татан буулгах болон өөрчлөн зохион байгуулахтай холбоотойгоор шүүгчийг өөрчлөн зохион байгуулагдсан шүүх эсхүл өөр шүүхэд шилжүүлэн томилохоос Ерөнхийлөгч татгалзах эрхгүй.

Шүүхийн бүтэц, зохион байгуулалтаар томилогдоогүй үлдсэн шүүгчдийг албан тушаалд нь нэн даруй буцаан томилох нь зүйтэй. Энэ байдлыг засаж залруулахгүй бол шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгааг алдагдуулсан төдийгүй цаашид ийм жишиг тогтох нөхцөл байдлыг үүсгэж байна.

¹ United States Institute of Peace “Judicial Appointments and Judicial independence” 2009, p-2

² Мөн тэнд.

³ Мөн тэнд.

⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оын 10 дугаар сарын 15-ны өдрийн 166 дугаар зарлигаар батлагдсан.

⁵ Ц. Норовдондог, Б. Буяндэлгэр, Ш. Хишигсүрэн, Ц.Түвшинзаяа “Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудалд” УИХ-ын Тамгын газар, Судалгааны төв Бодлогын судалгаа, шинжилгээ Судалгааны эмхтгэл IV боть УБ., 2010, 153 дахь тал.

⁶ Дэлгэрэнгүйг Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн судалгаа, мэдээллийн төв “Шүүхийн захиргааны байгууллагын бие даасан загвар, харьцуулсан тойм судалгаа” (УБ., 2013), УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв “Бодлогын судалгаа, шинжилгээ” (Судалгааны эмхтгэл) IV боть, (УБ., 2010), Латин Америкийн шүүхийн шинэтгэл https://media.law.wisc.edu/s/c_8/zfnfw/lhdjc.pdf -ээс үзнэ үү.

⁷ Хүний Эрхийн Үндэсний Комисс нь хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих байгууллага, нөгөө талаас шүүх нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн тогтоох зорилготой тул уг байгууллагын төлөөллийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

⁸ Уг тоон мэдээллийг 2015 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар гаргасан бөгөөд үүнээс хойш томилогдсон хүмүүсийг оруулаагүй болно.

⁹ <http://tsogt.blogmn.net/23110/>

¹⁰ Н.Багабанди Ерөнхийлөгчийн үед 2, Н.Энхбаяр Ерөнхийлөгчийн үед 4, Ц.Элбэгдорж Ерөнхийлөгчийн үед 21 удаа (21 тохиолдоос шүүхийн багц хууль хэрэгжиж эхэлснээс хойш 1, шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр дахин томилогдоогүй тохиолдол 13 удаа) гарсан байна.

¹¹ “Шүүгчийг сэлгэн ажиллуулах, шилжүүлэн томилохдоо хамгийн гол нь өөрийнх нь зөвшөөрлийг авах, хэрэв шүүгч зөвшөөрөл тухайн шүүгчийн амьдрал ахуй хөндөгдөхгүй (1. орон байр, 2, гэр бүлийн хүний ажил 3. үр хүүхдийн сургуулийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх) байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байгаагаа” санал асуулгад бичсэн байв.

¹² Уг судалгааг МУ-ын Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 198, 199 дүгээр зарлиг, 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 110, 111 дүгээр зарлиг болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, Иргэний хэргийн шүүхийн шийдвэр, ҮХЦ-ийн шийдвэр зэрэгт тулгуурлан гаргав.